


БАТЛАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,  
ТЕХНОЛОГИ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР



Д. ЦОЛМОНБААТАР

## ГАРААНЫ КОМПАНИЙН ТӨСӨЛ БОЙЖУУЛАХ “MUST START-UP 2.0” ХӨТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

**Хөтөлбөрийн зорилго:** ШУТИС-ийн 65 жилийн ойн хүрээнд гарааны компани байгуулах сонирхол бүхий багш, судлаачид, суралцагч болон төгсөгчдөд инновацийн төсөл бойжуулж, гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой хурдасгуур хөтөлбөр юм.

**Хөтөлбөрт хамрагдах шаардлага:** "MUST START-UP 2.0" хөтөлбөрт туршилт, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон технологи, оюуны өмч, ноу-хау-д тулгуурлан зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэвтрүүлэх зорилготой ШУТИС-ийн багш, судлаачид сонирхогч талууд (суралцагч, төгсөгч, гуравдагч этгээдтэй хамтарсан)-тай хамтарсан баг бүрдүүлэн хөтөлбөрт хамрагдах боломжтой ба хөтөлбөрт хамрагдах сонирхолтой баг дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Баг нь 3-аас дээш тооны гишүүнтэйгээр хүний нөөцөө бүрдүүлсэн байх;
- Багийн ахлагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны багш, судлаач байх;
- Багийн гишүүд нь бойжуулах хөтөлбөрт 20 долоо хоногийн хугацаа (сургалт, семинар, ментор зөвлөгөө)-нд бүрэн хамрагдах боломжтой байх;
- Зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төслийн санааг тухайн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн байх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загвар (prototype)-ыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн байх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь оюуны өмчийн эрхийн хамгаалагдсан хийгдсэн байх эсвэл давтагдаагүй байдлыг нотлон тайлбарласан байх;

**Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа:** Хөтөлбөрт шалгарсан багуудтай гэрээ байгуулснаас хойш нийт 20 долоо хоногийн хугацаанд үргэлжилнэ.

**Хөтөлбөрийн бүртгэл:** 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл бүртгэл явагдана.



Та бүртгүүлэхдээ дараахи холбоосоор (линк) хандаж эсвэл QR уншуулан өөрийн gmail хаягийг ашиглан бүртгүүлэх юм.

Линк: [bit.ly/3ZEcmnT](https://bit.ly/3ZEcmnT)

**Хөтөлбөрийн сонгон шалгаруулалт:** Хөтөлбөрийн шалгаруулалт 2 үе шаттай зохион байгуулагдана.

**Эхний шат:** Хөтөлбөрт бүртгүүлсэн багуудын мэдээлэлд (бүтээгдэхүүн, үйлчилгээний технологийн боломж, зах зээл, бизнесийн үр ашиг, баг бүрдүүлэлт г.м) үндэслэн 2 дахь шатанд шалгаруулна.

**Хоёрдугаар шат:** Энэ шатанд шалгарсан багуудын дунд зах зээлд нэвтрүүлэхээр зорьж буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах арга хэмжээ (pitch) зохион байгуулж “Гарааны компанийн төсөл бойжуулах MUST START-UP 2.0” хөтөлбөрт шалгарсан багуудтай гэрээ байгуулна.

**Хөтөлбөрийн хүрээнд гарах давуу тал, боломж:** Туршилт, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон технологи, оюуны өмч, ноу-хау-г зах зээлд нэвтрүүлж, амжилттай гарааны бизнесийг үүсгэн байгуулахад “MUST START-UP 2.0” хөтөлбөр дараах ач холбогдолтой.

- Хөтөлбөрийн үр дүнд инновацын төслөө амжилттай хөгжүүлж төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрх бүхий албан ёсны гарааны компанийг үүсгэн байгуулах;
- Гарааны санхүүжилт авах боломж (seed fund);
- Бизнесийн мэргэшсэн зөвлөхүүдээс зах зээл, бизнесийн орчны талаарх ментор үйлчилгээ авах, энтрепренер ур чадварт суралцах боломж;
- Өөрийн технологийн хүрээнд салбарын эксперт, профессор мэргэжилтнүүдээс мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, баталгаажуулах (tech validation);
- Судалгааны лаборатори, нарийн мэргэжлийн багаж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах;
- "MUST Sankou HUB" хамтын оффисын үйлчилгээ;
- ШУТИС-ийн орчин, дэд бүтэц, нөөцийг ашиглах (төслийн багт шаардлагатай оффис өрөө, уулзалт, хурал семинар зохион байгуулах заал, дадлага, туршилтын талбайгаар хангагдах гэх мэт);
- Харилцаа холбоо тэлэх (networking): Хөрөнгө оруулалт, технологи инновацын арга хэмжээ, олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармагт оролцож Старт-Ап экосистемд нэгдэх;

**Хөтөлбөрийн талаар мэдээлэл, зөвлөгөө авах:** Хөтөлбөрийн бүртгэл болон бусад асуудлаар мэдээлэл зөвлөгөө авах бол доорх хаягаар хандана.

**Хөтөлбөр хэрэгжүүлэгч:** ШУТИС-ийн Инновац, технологи дамжуулалтын төв

**Хаяг:** ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын төв байр (VIII)-ны 605 тоот өрөө

**И-мэйл:** [itto@must.edu.mn](mailto:itto@must.edu.mn)

ШУТИС-ИЙН ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТЫН ТӨВ